



**НИЙСЛЭЛИЙН  
АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/128

Улаанбаатар хот

**Байгууллагын онцгой байдлын  
түр хороо байгуулах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18, 16.5.1 дэх заалт, Улсын Онцгой Комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 12 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1241 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагад онцгой байдлын дэглэм тогтоон, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулан, онцгой тохиолдолд шуурхай арга хэмжээ авч ажиллах "Байгууллагын онцгой байдлын түр хороо"-г дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Түр хорооны дарга:	О.Алтангэрэл	Захиргааны хэлтсийн дарга
Гишүүд:	Г.Даваажаргал	Агаарын чанар, хяналт, зохион байгуулалтын хэлтсийн дарга
	Э.Энх-Амгалан	Агаар бохирдуулах суурин эх үүсвэр хариуцсан мэргэжилтэн
	Ч.Нэргүй	Агаарын чанарын хяналт хариуцсан мэргэжилтэн
	Г.Гончигдорж	Хэсэгчилсэн дулаан хангамж хариуцсан мэргэжилтэн
	Б.Оюунгэрэл	Диспетчер
Нарийн бичиг:	М.Отгонбаяр	Хөдөлгөөнт эх үүсвэрийн хэмжилт хариуцсан ахлах мэргэжилтэн

2. "Байгууллагын онцгой байдлын түр хороо" нь ажилтан, албан хаагчдыг онцгой үед ажиллах төлөвлөгөө гарган танилцуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Түр хороо /О.Алтангэрэл/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц. ЦОЛМОН

1150500261